

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЯВЦЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

2023.06.29

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлогын 5 тэргүүлэх зорилтод хамаарах нийт 11 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх 11 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийн тайланд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 36 хавсралт (ЗГ-ын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)-д заасан загвар хүснэгтээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнав.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

Бодлого, арга хэмжээгээр харуулбал:

- Эдийн засгийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний дундаж 60.0 хувь;
- Засаглалын бодлогын 3 зорилтын 9 арга хэмжээний дундаж 76.7 хувь.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилтот түвшингийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн явцын хэрэгжилт – **73.64% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Бодлого	
			Эдийн засаг	Засаглал
1	Хяналтад авсан зорилтын тоо	5	2	3
2	Хяналтад авсан арга хэмжээний тоо	11	2	9
3	100.0 хувь	2	-	2
4	90.0 хувь	2	-	2
5	70.0 хувь	4	1	3
6	50.0 хувь	3	1	2
7	30.0 хувь	-	-	-
8	Хэрэгжилтийн хувь	73.64 хувь	60.0 хувь	76.7 хувь

Гурав. Дүгнэлт

Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ, үүнээс бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээ тусгагдсан.

Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас шалтгаалсан, дангаар шийдвэрлэх боломжгүй, хөрөнгө санхүүжилтийн хувьд өндөр, дотоод боломж нөхцөлөөр хийгдэхгүй, цаг хугацаа шаардсан 3 арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд **4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-mongolia платформд холбоно.** энэ арга хэмжээг ТӨБЗГ-аас санал өгч тусгаагүй, алдаа үүссэн байх тул тус байгууллагаас хэрэгжилтийг тайлагнах боломжгүй тул хяналтаас хасуулах саналыг хүргүүлж байгаа болно.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтээр удаашралтай байгаа арга хэмжээг зохион байгуулалтын арга хэмжээ авч, эрчимжүүлэх;
- <https://new.unelgee.gov.mn>-нд тайлангийн хэрэгжилтийг зөвхөн 2000 тэмдэгтэд багтаан оруулдаг тул процессыг дурьдахгүй гарсан үр дүнг тайлагнаж байх.

Шийдвэрлүүлэх асуудал /Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд/

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний:

- “4.1.4.5. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно” гэсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбох арга хэмжээ нь ТӨБЗГазарт хамаарах заалт биш учраас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn-нээс хасалт хийлгүүлэх саналтай байна.

Танилцсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТӨН Д.ЦЭРЭНЛХАМ